



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 09/121

Улаанбаатар хот

Сургалтад оролцуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/311 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Азийн Том хотуудын холбооноос Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо 2019 оны 11 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулаас аврах, хямралын менежментийг сайжруулах нь" сэдэвт Олон Улсын сургалтад Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч Т.Зоригийг оролцуулсугай.

2. Олон Улсын сургалтад оролцоход шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Сургалтад шаардагдах 3.096.672 (гурван сая ерэн зургаан мянга зургаан зуун далан хоёр) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалтад оролцсон тухай дүнг ажлын 2 хоногт илтгэх хуудсаар танилцуулахыг Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч Т.Зоригт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн
1/121 дугаар тушаалын хавсралт



**“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, АЮУЛААС АВРАХ,
ХЯМРАЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ НЬ” СЭДЭВТ ОЛОН
УЛСЫН СУРГАЛТАД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын төрөл	Хүний тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Онгоцны тийз /УБ-Манила-УБ/	1	2,030,700 төгрөг	2,030,700 төгрөг	2,030,700 төгрөг
2	Зам хоног	1	40 ам.доллар	120 ам.доллар	320,592 төгрөг
3	Зочид буудал	1	93 ам.доллар	279 ам.доллар	745,376.400 төгрөг
нийт					3,096,672 төгрөг

Монгол банкны 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ханшаар 1 ам.доллар 2.671.600 төгрөг байна.

--oOo--